

Жишээ 1: Рожэр—Хэцүү цаг үеийг даван туулахад надад юу туслах вэ? (Матай 14:13–23)

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Матай 14:1–12-оос Херод баптисч Иоханыг цаазалсан гэдгийг бид олж мэдсэн. Өөрийн найз болох үеэл нь нас барсныг сонссон Есүст ямар байсныг төсөөл.

Матай 14:13–23-г Аврагчийн юу хийснийг судлаад, **хэдий бид өөрсдөө хүнд хэцүү цаг үеийг туулж байсан ч бусдад энэрэл нигүүлслээ харуулж, үйлчлэх замаар Есүс Христийн жишээг дагах боломжтой** гэх зарчмын нотолгоог олж, тэмдэглэ. “Зэлүүд газар” (13-р шүлэг) гэдэг нь хүн амьдардаггүй газар бөгөөд “хоол хүнс” (15-р шүлэг) гэдэг нь “идэж уух зүйлс” гэсэн утгатай болохыг анхаар.

- Энэ зарчмыг дэмжих юуг та эдгээр шүлгээс олж мэдсэн бэ?
- Баптисч Иоханыг хөнөөсөн талаар мэдсэнийхээ дараа Есүс юу хийсэн бэ?
- Их Эзэний амь биеэ умартан үйлчилсэн үлгэр жишээ зовж шаналж байгаа хэн нэгэнд хэрхэн туслах вэ?

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар бид хэрхэн Христийнхтэй адил зан чанарыг хөгжүүлж болох тухай заасан.



Өөрсдөө зовж шаналж байхдаа бусад хүний зовлон шаналлыг олж харах хүч, өлсөж байхдаа бусдын өлсөж байгааг мэдрэх чадвар, өөрсдөө сүнслэг харанхуйд байхдаа бусдын сүнслэг зовлонд туслах, өрөвч энэрэнгүй байх хүч чадал зэрэг нь бидний зан чанарыг харуулдаг. Бид эгэл чанараараа өөрсдийн асуудал, бэрхшээлд санаа тавьдаг бол харин бусдыг халамжилж, туслах үед бидний жинхэнэ зан чанар харагддаг. . . .

. . . Үнэнийг хэлэхэд, бид мөнх бус хүмүүний хувьд өөрсдөд маань хамгийн хурдан, хамгийн хүнд тусдаг зовлон бэрхшээл, сорилтыг туулж буй тэдгээр хүнд гараа сунган, тохиромжтой арга замаар хариу үйлдэл үзүүлэх чадвартай холбоотой сүнслэг бэлгүүдийг хүлээн авахын тулд зөв шударгаар хичээн зүтгэх боломжтой.

Бид зөвхөн өөрсдийн хүч эсвэл шийдэмгий байдлаар ийм чадварыг хүлээн авч чадахгүй. Харин бидэнд “Ариун Мессиагийн сайн үйл мөн нигүүлсэл, мөн ач ивээл” (2 Нифай 2:8) хэрэгтэй бөгөөд бид эдгээрээс хамааралтай байдаг. (David A. Bednar, quoted in Sarah Jane Weaver, “Elder Bednar Addresses ‘the Character of Christ’ during 2019 Mission Leadership Seminar,” *Church News*, July 9, 2019)

Олж мэдсэн зүйлээ хуваалцахаар бэлдэхдээ бусдад үйлчилснээр олж авсан туршлагаа тунгаан бод.

- Христийнхтэй адил үйлчлэх нь сорилт бэрхшээлээ даван туулахад хэрхэн бидэнд тусална гэж та бодож байна вэ?